

- Төмөр замын тээврийн тухай хуулийн 8.1.1-ийг үндэслэн УИХ-ын 32 дугаар тогтоолоор “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ыг баталсан.
- Бодлогын эхний үе шатанд “Даланзадгад – Тавантолгой – Зүүнбаян, Сайншанд – Баруун – Урт – Чойбалсан чиглэлд төмөр зам барихаар тусгасан.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

2010 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 32

Төрийн ордон, Улаанбаатар хот

Төрөөс төмөр замын тээврийн талаар
баримтлах бодлого батлах тухай

Төмөр замын тээврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ыг хавсралтаар баталсугай.

2.Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай:

1/Монгол Улсын экспортын ачааны тээвэрлэлтийг ОХУ болон БНХАУ-ын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэхэд тухайн улсын төмөр замын байгууллагаас ижил төрлийн ачааны тээвэрлэлтэд үзүүлж байгаа тээврийн болон вагон ашиглалтын хамгийн доод хөлс, ачаа хүргэх хугацаа, бусад төлбөр, хураамжтай дүйцэх буюу илүү хөнгөлөлттэй нөхцөлийг урт хугацаанд мөрдөхөөр тохиролцож, "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-д тусгагдсан тухайн чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах арга хэмжээ авах;

2/Эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой шинээр барих төмөр замын суурь бүтцийг Төмөр замын тээврийн тухай хуулийн 6.2-т заасны дагуу төрийн өмчид байлгах;

3/"Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-д заасан зорилтыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэх;

4/Даланзадгад - Таван толгой - Зүүнбаян, Сайншанд- Баруун – Урт - Чойбалсан чиглэлд жийгдэх бүтээн байгуулалтын ажлыг 2010 онд багтаан эхлүүлэх;

5/Энэ тогтоолын 2 дахь заалтын 4 дэх дэд заалтад заасан чиглэлтэй уялдуулан хөндлөн болон баруун босоо чиглэлд тавих төмөр замын замнал /маршрут/-ыг нарийвчлан тодорхойлж Улсын Их Хуралд танилцуулах;

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг барих хэрэгцээ, шаардлага

- Зүүн хойд Хятад, Япон, Солонгосын нийт коксжих нүүрсний эрэлт нь Монголын жилийн нийт олборлолтоос даруй 5 дахин их байна. Уул уурхайн компаниуд борлуулалтаа Хятадын зууч компаниудаар дамжуулан хийдэг тул эцсийн хэрэглэгчдийн оролцоо хязгаарлагдмал байгаа. Өнөөдрийн ашгийн ихэнх хувь Хятадын нүүрс зуучлагч нарт ноогдож байна.
- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын шугамыг барьж одоо байгаа дотоодын төмөр замын сүлжээгээр дамжуулан Орос, Хятадын төмөр замын сүлжээнд холбогдох, цаашилбал далайн боомтуудад хүрэх.
- Тавантолгойн ордын нүүрсийг Хятад, Солонгос, Японы зах зээлд хүргэх.
- Нэг зах зээлээс хамаарсан хамаарлыг бууруулах, Тавантолгойн нүүрсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилготой.
- Түүнчлэн жил бүрийн улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд Тавантолгойн орд газрыг түшиглэн нүүрс баяжуулах үйлдвэр, цахилгаан станц, цахилгаан дамжуулах шугам, төмөр зам, авто зам барьж нийгэм, эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг тооцоолсон хэмжээнд хүргэх, экспортын орлогыг нэмэгдүүлэн, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн экспортод гаргах зорилт тусгагдсан байдаг.



Тавантолгой – Зүүнбаян чиглэлийн төмөр замын ерөнхий үзүүлэлт



Техникийн үзүүлэлт:

Гол замын урт	414.6 км
Дэлгэмэл урт	486.6 км
Өртөө	1
Зөрлөг	6
Удирдах хэвгий	9 промиль
Голын даац	25 тонн
Цариг	1520 мм
Төсөвт өртөг	2.4 их наяд төгрөг

Доод бүтцийн ажил:


Газар шорооны ажил	36,481,586 м3
Дөрвөлжин хоолой	65 ш
Дугуй хоолой	461 ш
Гүүрийн ажил	32ш, 2580м урт

Дээд бүтцийн ажил:

Зам төмөр	63263,1 тн
Бетон дэр, бэхэлгээ	950544 ш
Балласт	910,625 м3
Суман шилжүүлэг	102 ш



ТАВАН ТОЛГОЙ-ЗҮҮНБЯАН ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН ТРАССЫН ДАГУУХ 30 КМ-ИЙН БҮСД ОРСОН ХЯЗГААРЛАСАН, ХОРИГЛОСОН, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ТАЛБАЙН БАЙРШЛЫН ЗУРАГ
МАСШТАБ 1:800000



Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын трассын дагуух 30 км-ийн бүсэд зөвхөн Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий ашигт малтмалын орд газрууд нийт 37 байна. Тавантолгойн нүүрсний ордоос гадна Цагаан суврагын зэсийн орд, Хармагтайн зэс алтны орд, Манлайн нүүрсний орд зэрэг нүүрс, зэс, алт, гөлтгөнө, цеолит, ураны томоохон ордууд байршиж байгаа бөгөөд 6.02 тэрбум тоннын нөөц бүхий баялаг байна. Төмөр зам баригдсанаар эдгээр орд газар эдийн засгийн эргэлтэнд орох боломж бүрдэж байна.

Төслийн нийгэм, эдийн засгийн ач холбогдол:

- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам баригдаж, “УБТЗ” ХНН-ийн гол замтай холбогдон төмөр замын нэгдсэн сүлжээ ашиглалтад орсноор Монгол Улсын эдийн засагт бодит үр өгөөж өгөх ба БНХАУ болон ОХУ-ын газар нутгаар дамжин далайн чанад дахь зах зээлд хүрч экспортын хоёр ба гурав дахь шинэ гарцуудыг бий болгож эцсийн хэрэглэгчид шууд хүргэх, далайн боомт нөхцөлөөр бүтээгдэхүүнийг борлуулах нөхцөл бүрдэнэ. Өнөөгийн байдлаар манай улс уурхайн ам нөхцөлөөр хямд үнээр борлуулж байна.
- Нүүрсний тээвэрлэлтийн зардлыг багасгаж, БНХАУ-ын коксжих нүүрс импортлогч хамгийн том бүсүүд болох Хэбэй, Ляонин мужууд дахь үйлдвэрүүдэд хямд зардлаар нүүрс хүргэх ач холбогдолтой.
- Тус төмөр зам баригдсанаар Тавантолгойн коксжих нүүрсний 1 худалдан авагч, нэг зах зээлээс хамаарсан үнийн өрсөлдөөнгүй байдлыг байхгүй болгоно. Зүүн хойд Хятадын зах зээлд эрэлтэд тулгуурласан, үнийн өрсөлдөөнт байдлаар олон гарцаар зэрэг нийлүүлэх, мөн түүнчлэн БНХАУ, ОХУ-аар дамжин далайн чанад дахь Япон, Солонгос зэрэг гуравдагч зах зээлд өндөр үнээр уул уурхайн бүтээгдэхүүнийг нийлүүлж борлуулах боломж бүрдэнэ.
- Төмөр замын нэгдсэн сүлжээг барьж байгуулснаар Монгол Улс ашигт малтмалын нөөц бүхий идэвхигүй байгаа ордуудаа ашиглах, олон улсын үнэ тарифаар худалдан авагчдад түгээх боломж бүрэн нээгднэ.
- Монгол Улс төмөр замын сүлжээг стратегийн орд газрууд болон томоохон төслүүдтэйгээ холбосноор Аж үйлдвэрийн парк байгуулах, нэмүү өртөг шингэсэн боловсруулсан уул уурхайн бүтээгдэхүүнийг олон улсад гаргах эдийн засгийн томоохон боломжийг бий болгоно.



Төслийн нийгэм, эдийн засгийн ач холбогдол:

- Улс орны хөгжилд стратегийн ач холбогдолтой, чухал бүтээгдэхүүний нэг ган бөгөөд түүнийг гарган авдаг гол түүхий эд нь коксжих нүүрс, төмрийн хүдэр юм. Монгол улс коксжих нүүрс, төмрийн хүдрийн арвин нөөцтэй бөгөөд Сайншандад Дархан, Сэлэнгийн бүсийн төмрийн хүдрийг Тавантолгой коксжих нүүрсээр боловсруулан ган үйлдвэрлэж дотоодын хэрэгцээг хангах, улмаар ган металлургийн хүнд үйлдвэрлэл хөгжих, экспортлох боломжтой болно.
- Тавантолгойн коксжих нүүрсний олборлолт, нийлүүлэлтийн хэмжээ өнөөгийн түвшнээс 2 дахин нэмэгдэх боломж бүрдэх бөгөөд БНХАУ руу экспортлох эерэг хамааралт бүтээгдэхүүн болох төмрийн хүдрийн экспортын хэмжээг нэмэгдүүлэх боломжтой болно.
- Төмөр замын дэд бүтэц хөгжихийн зэрэгцээгээр бэлчээр сүйтгэх, тоосжилт, дуу шуугиан, хөрс болон агаарын бохирдлын асуудал үлэмж хэмжээгээр багасна.
- Зүүнбаян нь Дорноговь аймгийн нутагт орших тосгон бөгөөд засаг захиргааны хувьд Сайншанд сумын нэг баг юм. 3000 гаруй оршин суугчтай. Зүүнбаян тосгоны хүн ам 2-3 дахин өсч, 7-10 мянган хүн амтай томоохон суурьшлын төв бий болно. Тавантолгойн нүүрсний уурхай, Тавантолгойн төмөр замын өртөө байрлах Өмнөговь аймгийн Цогтцэций сум мөн адил томоохон суурьшлын төв болон хөгжих болно. Хүн амын суурьшил дагасан хөнгөн болон хүнд үйлдвэр хөгжинө.
- Орон нутагт ажлын байр нэмэгдэнэ. Өмнөговь, Дорноговь аймагт төмөр замын уг чиглэл ашиглалтанд орсноор 1000 орчим шууд ажлын байр, төмөр замыг дагаад олон ажлын байр шинээр бий болохоос гадна олборлолтын хэмжээ нэмэгдсэнээр уурхайнууд, тэдгээрт үйлчлэх салбаруудын олон мянган ажлын байр хадгалагдаж, нэмэгдэнэ.
- Төмөр зам баригдсанаар зөвхөн уул уурхайн салбарт бус хүнс, мал аж ахуйн салбар, арьс ширний үйлдвэрлэл, тэдгээрийн логистикт чухал нөлөөг үзүүлнэ. Бүс нутгийн харилцаа, хамтын ажиллагаа улам бүр хөгжинө.